

дическими материалами. Учебники по эвенкийскому языку выпускают в издательствах «Просвещение», «Дрофа» (Санкт-Петербург). В Республиках Бурятия и Саха (Якутия) издается научная и учебная литература на эвенкийском языке. Это словари, сборники сказок, пословиц и поговорок, программы, учебные и учебно-методические пособия для учащихся школ и студентов вузов. Научную литературу по эвенкийскому фольклору, этнографии и этнокультуре эвенков издают научные центры СО РАН гг. Новосибирск, Владивосток, Якутск, также гг. Санкт-Петербург, Москва.

Вместе с тем остаются неисследованными многие говоры, в том числе эвенков Бурятии. Учитывая языковую ситуацию с сохранением эвенкийского языка, в Бурятском государственном университете разрабатывается мультимедийный (звуковой) фонд современного эвенкийского языка на представительном звуковом материале. Содержание фонда: звуко- и видеозаписи собирались на протяжении нескольких лет в ходе полевых экспедиций в места компактного проживания эвенков на территории России и Китая.

Таким образом, для сохранения и функционирования эвенкийского языка в России требуются усилия как государственных органов, так и общественности в лице этнических сообществ, самих представителей этноса.

#### *Литература*

1. Вахтин Н.Б. Языки народов Севера в XX веке. Очерки языкового сдвига. СПб: Дмитрий Буланин, 2001.

#### *References (transliterated)*

1. Vaxtin N.B. Yazyki narodov Severa v XX veke. Ocherki yazykovogo sdviga. Spb: Dmitriy Bulanin, 2001.

УДК 81-2

doi: 10.18101/978-5-9793-0814-2-126-129

### **Словообразование в современном монгольском языке путем сокращений и аббревиатур: подходы к унификации и нормированию**

© **Эрдэнэтуул Боронгоо**

преподаватель Архангайского института Монгольского университета образования, г.Улан-Батор, Монголия.

Целью сокращения слов в современном речевом общении является стремление облегчить процесс коммуникации, сэкономить время. В настоящее время существует необходимость в регулировании этого процесса в целях исключения негативных тенденций, унификации правил сокращения слов и составления аббревиатур в монгольском языке.

**Ключевые слова:** правила сокращения слов, современная языковая ситуация, нарушение языковых норм, нормы регулирования процесса сокращения слов

### **Word-formation in the modern Mongolian language through abbreviations and acronyms: the approaches to standardization and norming**

**Erdenetuul Borongoo**

Lecturer, Mongolia, Ulaanbaatar, Mongolian State University of Education, Arkhangai Institute.

The purpose of shortening of words in modern speech communication is to facilitate the communication process, to save time. Currently there is a need to regulate this process in order to avoid negative trends, unification of the rules of shortening words and making abbreviations in the Mongolian language.

**Keywords:** rules abbreviations of words, modern language situation, the violation of linguistic norms, norms of regulation of the process of reducing words

Үг товчлох ёс бол хэл ярианы харилцааг хөнгөвчлөх, цаг хэмнэх, цаас арвилан, ажил хөнгөвчлөх үүрэгтэйгээр үүсдэг бөгөөд мэдээллийг түргэн шуурхай, товч илэрхийлэх үндсэн зорилготой байдаг. Үүнийг эрдэмтэд, судлаачид “хэлэх, бичихийн хэмнэл[4]” гэж нэрлэдэг. Гэхдээ товчилсон үг бүрийг өргөн олон нийт төдий л хялбархан онож уншихад бэрхтэй тул үг болгоныг товчилдоггүй, олноороо мэддэг болсон юмны нэрийг товчилж бичдэг.

Улс хоорондын харилцаа өргөжиж, шинжлэх ухаан технологийн мэдээлэл хөгжсөн өнөө үед аливаа улсын хэлний тользүй, үгийн санд товчилсон үг, хураасан үгийн эзлэх байр нэмэгдэж, дэлгэрэнгүй утга санаа, бүхэл бүтэн ухагдахууныг үг товчлолын аргаар хураангуй илэрхийлэх буюу томъёолсон тэмдэг хэрэглэх явдал юм[3].

Манай монгол хэл нь түүхэн хөгжлийнхөө үе үеийн туршид шинэ үг хэллэг, утгаар баяжиж, дагавар нөхцөл, үг өгүүлбэрийн сан хөмрөг нь арвижиж, хэрэглээний талбар нь улам тэлсээр иржээ. Үүний наад захын жишээ бол үг товчлох аргаар өдий төдий шинэ үг үүсч, "товчилсон хэвшмэл нэр"-ээр үгийн сан баяжиж буй баримт юм [8].

Монгол хэлний товчилсон үгийг алиа марзан утгаар юм уу, эсвэл буруу хазгай тайлбарлах явдал байгааг зориуд хэлмээр байна. Төвийн сонин хэвлэлд "АРХИ" гэсэн үгийг "амтат рашаан, хүндэтгэлийн идээ", "ГААЛЬ" гэдэг үгийг "гадаадаас авчирвал авилгал аль" ("Зууны мэдээ" сонин, №251 /2699/.2007.Х.19), "ГСА" (Говьсүмбэр аймаг) гэсэн товчилсон үгийг "гурван сумтай аймаг" ("Өнөөдөр" сонин №8 /3571/.2009.1.13), "ТУЗ" (Төлөөлөн удирдах зөвлөл) гэсэн товчилсон үгийг "төлөөлөн урьтаж завш" ("Зууны мэдээ" сонин, №251 /2699/.2007.Х.19) гэж гаж буруу тайлбарлах нь мэр сэр үзэгдэх боллоо.

Монголч эрдэмтэн Д.Кара 1998 онд нийтлүүлсэн "Монгол-мажар товч толь"-доо "БНМАУ" гэсэн товчилсон үгийг "бүгдээрээ нийлээд манайд архи ууя", "ЗООГ" гэсэн товчилсон үгийг "залуу охидыг отох газар" гэхчилэн тайлан унших боломжтойг цухасхан дурдсан нь үг хэллэгийн гаж үзэгдэлтэй холбоотой байна.

Өрнөдийн бичиг зохиолын хэлэнд ХИУ зууны үед латин хэлнээс уламжлагдан ороод, хожим нь орос бичгийн хэлэнд нэвтэрч орсон "аббревиатура" (abbreviation) хэмээх энэхүү нэр томъёог "хурдан бичих, мөн зай хэмнэх үүднээс ямар нэгэн үг хэллэгийг тусгай тэмдгээр хураангуйлах буюу үгийг үсгээр товчлон богиносгох арга" гэж үздэг байжээ.

Орос хэлэнд үгийг товчлохдоо дараах хэлбэрээр бичдэг байна. Үүнд :

1. Толгой үсгээр товчлон бичдэг. Ингэж бичихдээ 3 төрөл болгон ангилдаг.

а. Үгийг эхний үсгээр нь эхлэн товчлох : Жишээ нь: СССР (эс-эс-эс-эр)-Союз Советских Социалистических Республик, ГЭС-Гидро Электро Станция гэх мэт.

б. Үгийг дуудлагаар нь товчлон дуудах, энгийн үгийг товчлох : Жишээ нь : вуз-высшее учебное заведение /Их, дээд сургууль/

в. Үсэг авиагаар товчлох: Үгийг эхний үсэг, сүүлийн хоёр үгийг авиагаар нь эхлэн товчлох. Жишээ нь : ЦДСА (цэ-дэ-са)-Центральный дом Советской Армии;

2. Үгийн хэсгээс товчлох. Жишээ нь : партком-партийный комитет;

3. Холимог төрөл нь үгийн хэсэг авиагаар товчлон бичдэг. Жишээ нь : гороно-гор. отдел нар. Образования;

4. Үгийн хэсгээс болон бүтэн үгээр товчлох арга байдаг. Жишээ нь : запчастн-запасные части;

5. Үгийн эхний хэсэгтээ хослуулан товчлоно. Жишээ нь: завкафедрой-заведующий кафедрой;

6. Үгийн эхнээс болон 2 дахь үгийн төгсгөлөөс товчлон бичдэг. Жишээ нь : мопед-мотоцикл-велосипед.

Үүнтэй холбогдуулж хэлэхэд, английн нэрт жүжгийн зохиолч В.Шекспир (1564-1616) "This is the short and the long of it" [Энэ бол үүний гол санаа мөн] хэмээсэн байдгийг дурдалтай. Өөрөөр хэлбэл, товчилсон үг нь тухайн товчлогдсон үгсийнхээ үндсэн утга санааг илэрхийлдэг гэсэн үг юм.

Англи хэлэнд "abbreviation" гэдгийн дор "initialism", "acronym", "alphabetism" гэж гурван янзын хэлбэрээр үг товчилж хураадаг уламжлалтай юм. Тухайлбал:

1. "Initialism" буюу эхний үсгээр товчилно. Жишээ нь: BBC, MP, PhD, TV, USA, VIP.

2. "Acronym" буюу үсэг товчлолоор үг бүтээнэ. Жишээлбэл: "Light amplification stimulated emission of radiation" гэж товчлоод "LASER" гэсэн үг бүтээсэн. Мөн "NATO" "UNESCO".

3. Англи хэлэнд "clipping" нь үгийг үеэр нь хугаслаж цомхотгодог. Ер нь "to vlip" гэвэл "хайчлах", "тайрах" гэсэн үг, "хумсны хайч" гэвэл "nail-clipper" юм. Дуучны "clip" гэдэг нь кинонд тогложон жүжигчдийн хальсыг хайчилж, дуулж байгаа дуучны ард хөдөлгөөн үүсгэж, сонсогчийг татах дууны найруулгад хэрэглэсэнээр үүссэн зүйл. Хэл бичигт "clipping" буюу "цомхотгол" нь "democratic" гэснийг "demo", "examination" гэхийг "exam", "public" гэхийг "pub", "autobus" гэхийг "bus", "airplane" гэхийг "plane", хөргөгчийг "fridge", ханиадыг "flu", "Elizabeth"-ийг "Betty", "William"-ыг "Billy" гэх мэтээр хугаслаад, хэл яриандаа өргөн хэрэглэдэг ажээ.

4. Сүүлийн үед англи хэлэнд "blending" (blends) гэсэн үг хураах нэг төрлийн арга түгээмэл хэрэглэгдэх боллоо. Хоёр үгний эхний үгийнх нь эхний үеийг, хоёрдугаар үеийнх нь сүүлчийн үетэй залгалдуулан нийлүүлж нэг үг бүтээж болдог. Жишээ нь: "breakfast"+"lunch" хоёроос "brunch" гэсэн үг үүсгэдэг. "Helicopter"+"airport" гэснийг "heliport", "smoke"+"fog"-оос "smog" (хүдэн), Channel"+"tunnel" –аас "Chunnel" хэмээх үг шинээр үүсэн гарчээ.

"Монгол бичгийн хэлэнд үгийг үсгээр товчлох ёс бараг байгаагүй юм. Харин үлэмжхэн хүндэтгэл үзүүлэх, нэр цээрлэх ёсны үүднээс "То ван", "түшмэл На, "Сү жанжин", "Лу багш" гэх мэтээр нэрийг үеэр хураан, хүндэтгэн авгайлж хэлдэг байжээ. Товчилсон үгийг бүтэц бүрэлдэхүүнийх нь хувьд:

1. Үсгээр товчилсон үг
2. Үеэр товчилсон үг
3. Холимоор товчилсон үг гэсэн гурван үндсэн хэсэгт хувааж болмоор байна.

Сүүлийн үед монгол хэлэнд үг товчлох нь эрс нэмэгдлээ. ...Монгол хэлний үг товчлох ёсыг хэтрүүлж, журам дүрэмгүй хамаагүй товчилбол уншигч олонд ойлгогдохгүй, оньсого таавар шиг юм болоод ард түмэнд ном хэвлэлээр үйлчлэхэд саад учруулж болно. Иймийн тул үг товчлох дүрэм журмыг сайжруулан боловсруулах нь чухал байна. Үг товчлон хураангуйлах нь үг бүтэх ёсны хамгийн идэвхтэй арга болж байна.

Эдүгээ МОНЦАМЭ, ТӨХ, СӨХ, МИАТ, НЭТ, НӨТ, ГОК, ДОХ, АПУ, САПУ, ШАГ, ТҮЦ, ТУЗ, ХАС банк, ХААН банк, АНОД банк гэх мэт товчилсон үгс нь “нэршсэн нэр” болж, хэвшиж тогтсон байдаг. Эдгээр товчилсон үгээс үүссэн “нэршсэн нэр” нь үсгийн байрлал, дараалал нь монгол хэлний үгийн бүтэцтэй тун төстэй бөгөөд хэлэх дуудахад тохиромжтой тул товчилсон үг хэвээр дуудах боломжтой байдаг. Үг товчлон хураангуйлах нь үг бүтэх ёсны гол арга болж байгаа хэдий ч үг товчлох ёс, уламжлал, монгол хэлний үгийн бүтэц, хэлзүйн онцлогийг гажуудуулсан зүй бус хэрэглээ газар авч байна. Тухайлбал:

1. Сүүлийн хориод жилд албан газар, үйлдвэр үйлчилгээ, аж ахуйн нэгж байгууллагуудын оноосон нэр нь “ОМГХКСТ” сургалтын төв, “БОСММ” ХХК, “ХДЯБТТ”, “МҮХАҮТ”, “ШБӨХЗГ гэх мэт гэхчилэн хэн ч тайлж уншихын аргагүй, хэд хэдэн үсгийн цуглуулга төдий товчлол болсон нь эх хэлний хэрэглээ, соёлыг гажуудуулсан сөрөг үзэгдэл юм.

2. Уншигч олон нийтэд ойгомжгүй, оньсого таавар мэт шинэ үг хэллэг, оноосон нэрийг сонин сэтгүүл, хэвлэл мэдээллийн найруулгад (“Зууны мэдээ”, “Засгийн газрын мэдээ”, “МонЦаМэ”, “Өнөөдөр” зэрэг өдөр тутмын сонинг сонгон авч товчилсон үгийн хүрээнд ажиглалт хийвэл, 560 орчим товчилсон үгийн 90% нь эх бичвэрийн тайлбар зүүлт хийгээгүй, 33,1 % “Монгол хэлний товчилсон үгийн толь бичиг”-т ороогүй байх жишээтэй. “Засгийн газрын мэдээ” сонин, 1998.05.22 №103-т “ОӨХТ”, “ҮГӨБТ”, “ОУХДК”, “Зууны мэдээ” сонин, 2009.06.26 №145-д “ГИХАЭГ”, “УКТЭ”, “ЭЗНДНТУТХ”, МҮОН-ийн телевизийн шууд нэвтрүүлэг, 2014.07.18 гэх мэт) зүүлт тайлбаргүйгээр бичиж, хэвлэн нийтлэх нь ердийн үзэгдэл болжээ.

3. Монгол хэлний товчилсон үгийн дотор (км, гек, ЛАЗЕР, САМБО, ТАСС, АСЕАН...) зэрэг харь хэлнээс гарал бүхий олон улсын шинж чанартай үг, нэр томъёо цөөнгүй байдаг. Сүүлийн үед “харь хэлний үгийг зүй зохистой хэрэглэх, зөв оноон орчуулах, эх хэлээ эрхэмлэн дээдлэх” гэдгийг хайхрахгүй болсонтой холбогдон үг хурааж, шинэ нэрлэлт үүсэх зүй тогтол нь үгсийн бүрэлдэхүүний хувьд (Цэн Гүн Трейд, “Мон зуух проект” ХХК, Монфреш ХХК, “Ай Эс Си” Монгол трейд) холимог байх нь давамгайлах болжээ. Албан байгууллагын нэр хаяг, сонин сэтгүүлээс нийт 610 орчим товчилсон үгийг түүвэрлэн үгсийн бүрэлдэхүүний талаас ажиглахад 45,3 хувь нь гадаад, 30,7 хувь нь холимог, 24 % нь монгол үгийг товчлон хурааж бүтсэн байна.

4. Монгол хэлний товчилсон үгийг бүтцийн талаас нь үсгээр товчилсон, үеэр товчилсон, холимог-гоор товчилсон гэж ангилан авч үздэг. Үсгээр, үеэр, холимог-гоор товчилж шинэ нэрлэлт үүсгэхэд анхаарах, баримтлах монгол хэлний дүрэм гэж байдаг атал “МОНЭС /Монголын эмэгтэйчүүдийн сан/, Мон зуух проект, “Энх Б” эмнэлэг, “Монг эм” ХХК, Мон Со Баян” эмнэлэг, “ББ ноён” ХХК гэх мэт аж ахуйн нэгж байгууллагуудын товчилсон нэрүүд түгээмэл болсон нь товчилсон үгийн бүтэц, тэр дундаа холмог-гоор хэрхэн товчлох тухай дүрэм журам байдгийг мэддэггүйнх нь үг хэллэгийн гаж үзэгдэлтэй холбоотой юм.

Иймээс монгол хэлний үг товчлох, хураах ёс, дүрэм журам, хэрэглээ, соёлын талд бий болсон энэ мэт сөрөг үзэгдлийг таслан зогсоож, журамлах цаг нэгэнт болсон мэт санагдана.

Үүний тулд:

1. Сонин нийтлэл, хэвлэл мэдээллийн найруулгад товчилсон үгийг заавал эх бичвэрийн тайлбартайгаар хэвлэн нийтлэх шаардлага тавьж, хэрэгжүүлэх,

2. Албан газар, байгууллага, аж ахуйн нэгжийн нэрийг батлахдаа хэрхэн товчлон, хурааж нэрлэх тухай асуудлыг хянан шийдвэрлэж байх,

3. Товчилсон үгийн тольд ороогүй үгийг хэвлэн нийтлэхийг хориглох

4. Гадаад үгийг зүй зохистой хэрэглэх, харь хэлний үгийг эх хэлнээ тохирсон үгээр нь зөв оноон хөрвүүлэх,

5. Ард нийтээр мэддэг болсон ухагдахуун ойлголтыг товчлон бичих,

6. Хувь хүмүүс, албан байгууллага, сонин хэвлэлийнхэн гээд хэн бүхэн “Үг товчлох, хураах тухай” дүрмийг дагаж баримтлах зэрэг асуудлыг тусгасан эх хэл, бичгийн асуудлыг цогц байдлаар авч үзсэн хуулийг боловсруулж, мөрдөн хэрэгжүүлэх шаардлагатай байна.

### *Литература*

1. Ж.Бат-Ирээдүй, Алан Сандерс., Товчилсон үгийн толь бичиг,УБ., 2006
2. Ц.Дамдинсүрэн,Монгол хэл бичгийн тухай,УБ.,1957
3. Ц.Дашдондов,Орос хэлний хураангуйлсан үгийн толь,УБ.,1975
4. Ц.Өнөрбаян,Орчин цагийн монгол хэлний үгзүй,УБ.,1998
5. Л.Түдэв, Хэлний дарангуйлал, МУБИС, МоСС-ийн Монгол судлалын чуулган,УБ., 2009
6. Э.Пүрэвжав, Монгол хэлний хэм хэмжээ, УБ., 1996
7. Э.Пүрэвжав,Монгол хэлний товчилсон үгийн толь,УБ., 2010
8. Б.Пүрэв-Очир,Үг, өгүүлбэрийн амьдрал араншин, эрчим энерги, соёл хэрэглээ,УБ., 2009
9. Б.Пүрэв-Очир, Монгол хэлний бүтэц, утга, хэрэглээ, УБ., 2007
10. Б.Пүрэв-Очир, Монгол хэлний товчилсон үгийн эргэн тойронд,УБ., 2010

### *References*

1. Zh. Bat-Ireeduj, Alan Sanders. Tovchilson ugijn tol'. UB, 2006.
2. Ts. Damdinsuren. Mongol hjel bichgijn tuhaj. UB, 1957.
3. Ts. Dashdondov. Oros helnij huraangujlsan ugijn tol'. UB, 1975.
4. Ts. Onorbajan. Orchin tsagijn mongol hjelnij ugzu. UB,1998.
5. L. Tudev. Helnij darangujlal. MUBIS, MoSS-ijn Mongol sudlalijn chuulgan, UB, 2009.
6. E. Purevzhav. Mongol hjelnij hem hemzhee, UB, 1996.
7. E. Purevzhav. Mongol hjelnij tovchilson ugijn tol'. UB, 2010.
8. B. Purevochir. Ug oguulberijn am'dralaranshin, erchim enjergi soyol hereglee, UB, 2009.
9. B. Purevochir. Mongol hjelnii butets, utga, hereglee, UB, 2007.
10. B. Purevochir. Mongol hjelnii tovchilson ugijn ergen tojrond. UB, 2010.

УДК 82-1(510)

doi: 10.18101/978-5-9793-0814-2-129-131

## **Элементы романтизма в творчестве китайского поэта Хайцзы**

### **© Цыбикова Валентина Владимировна**

ассистент кафедры Филологии стран Дальнего Востока Восточного института Бурятского государственного университета, г.Улан-Удэ

E-mail: [valyaca@yahoo.com](mailto:valyaca@yahoo.com)

Китайская современная литература включает в себя огромное количество выдающихся и талантливых поэтов и писателей, чье творчество явилось результатом политики реформ и открытости. В литературных кругах 1980-х гг. важное место занимал поэт Хайцзы. Его поэзия представляет синтез традиционной поэтической мысли Китая с передовыми западными идеями романтизма, экзистенциализма. Данная статья посвящена изучению некоторых элементов романтизма в творчестве китайского поэта Хайцзы, определивших своеобразие его поэзии. Идеи о бесконечности и абсолютности времени и бытия, одиночество лирического героя – бунтаря легли в основу многих его произведений. Дополняют романтическую картину художественного мира китайского поэта стремление к странствиям и поиску истины. В своих произведениях Хайцзы размышляет о предназначении человека в мире и об особой роли и ответственности поэта-творца.

**Ключевые слова:** романтизм, современная китайская литература, поэзия Хайцзы, бесконечность времени и бытия, герой-бунтарь, художественные особенности

## **Elements of romanticism in Hai Zi's works of art**

### **Valentina V. Tsybikova**

Assistant, Ulan-Ude, Buryat State University, Oriental Studies Institute, Department of the Far East Countries Philology

Chinese contemporary literature includes a wide variety talented and outstanding poets and writers. Their works of art were the results of political reform and opening up. In the world of 1980s literature the important place were hold by Chinese poet Haizi. His poetry was the synthesis of Chinese traditional poetic ideas and western ideas of Romanticism and existentialism. This article is devoted to the investigation of Romanticism features in Haizi's poetry. The idea of eternity and absolute of time and existence, persona's loneliness and rebellion were the foundation and peculiarity of his works of art. Striving to wandering and searching the truth add the artistic space of Romanticism picture. In his works of art Haizi pores at a problem of human destiny in the world and especially at the problem of poet's destiny and charge, as a creator.

**Keywords:** Romanticism, modern Chinese literature, the poetry of Hai Zi, the infinity of time and being, a rebel hero, artistic features

Современная китайская поэзия представлена огромным количеством талантливых поэтов, среди которых важное место занимает поэт Хайцзы, для творчества которого, в определенном смысле, свойственны и тенденции романтизма. В произведениях он рассуждает о первоначале человеческого